

## **Маргааны товч:**

Хадгаламжийн даатгалын корпорацийн хянан шалгагч, улсын байцаагчийн 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 0056514 тоот шийтгэлийн хуудсаар “Худалдаа хөгжлийн банк” ХК-д Зөрчлийн тухай хуулийн 11.12 дугаар зүйлийн 8-д зааснаар 20,000,000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулжээ.

Гомдол гаргагчаас “Хадгаламжийн даатгалын корпорациас удаа дараа “нэг харилцагчийн зарчим” буюу SCV загвараар тайлан мэдээлэл бэлтгэн ирүүлэхийг шаардсаар байгаа бөгөөд тухайн зарчим/загвар нь Хадгаламжийн даатгалын үндэсний хорооны 2018 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 62 дугаар тогтоолоор батлагдсан боловч захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд одоог хүртэл бүртгэгдээгүй. Нэг харилцагчийн зарчим буюу SCV загвар нь Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлагыг зөрчсөн байх тул захиргааны хэм хэмжээний актын эрх зүйн үйлчлэлгүй. Банк нь мэдээлэл хариуцагч бөгөөд харилцагчийн мэдээллийг хуулиар хамгаалах үүрэг хүлээсэн этгээд тул Хадгаламжийн даатгалын корпораци нь хуулийн хувьд хүчин төгөлдөр болоогүй загвараар тайлан авахыг банкнаас шаардаж байгаа нь хууль зөрчсөн үйлдэл юм. Иймд гомдлын шаардлагыг хангаж өгнө үү...” гэжээ.

Хариуцагчаас үүнийг эс зөвшөөрч “нэг харилцагчийн зарчим” буюу SCV загвараар мэдээллийг авдаг, нэхэмжлэгч тус загвараар тайлан мэдээллийг бэлтгэж ирүүлэхгүй байгаа нь зөрчилд тооцогдох тул Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон Хадгаламжийн даатгалын Үндэсний хорооны 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн тогтоолоор батлагдаж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэн “Банкны тайлан болон мэдээ, мэдээлэл ирүүлэх журам”-ын дагуу зөрчлийн арга хэмжээ авах үндэслэлтэй. Нэг харилцагчийн зарчим буюу SCV загвар нь уг журмын хүрээнд гаргасан зөвхөн мэдээлэл бэлтгэх загвар аргачлал бөгөөд ямар нэгэн харилцааг зохицуулахгүй тул захиргааны хэм хэмжээний актаар бүртгүүлэх шаардлагагүй. Хадгаламжийн даатгалын корпораци нь Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн дагуу дотоод мэдээллийн нууцыг хадгалах үүрэгтэй, мэдээллийг хүлээн авдаг албан тушаалтан нь холбогдох журмын дагуу нууцлалыг ханган ажилладаг тул ХХБ мэдээлэл өгөхөөс татгалзаж байгаа нь үндэслэлгүй...” гэж маргажээ.